

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

2022 оны 04 дүгээр
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

НЭГ. АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төрийн аудитын байгууллага 2021 онд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2020 оны 04, 05 дугаар тогтоол, 2021 оны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын гүйцэтгэх аудитын сэдэв батлах тухай” А/15, “Төрийн аудитын байгууллагаас 2021 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө” А/28 дугаар тушаалуудыг батлан хэрэгжүүлсэн байна.

1.1. Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос баталсан сэдвийн хүрээнд хийгдсэн аудитын ажлын хэрэгжилт

Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг үндэслэн Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 05 дугаар тогтоолоор Үндэсний аудитын газрын 2021 онд гүйцэтгэх аудитын сэдвийг баталсан. Тогтоолын хавсралтаар 2021 онд он дамжин гүйцэтгэх 2 аудит, хуулийн дагуу гүйцэтгэх 22 аудит, төрийн аудитын байгууллагын бодлогоор гүйцэтгэх 6 аудит, нийт 30 сэдвийн хүрээнд аудит хийж гүйцэтгэхээр тусгасан.

Төсвийн байнгын хорооны 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 02 дугаар тогтоолоор Төрийн аудитын байгууллагын 2021 онд гүйцэтгэх аудитын сэдэвт өөрчлөлт оруулсан. Энэхүү тогтоолын хавсралтад Төрийн аудитын байгууллагаас 2021 онд нийт 34 сэдвийн хүрээнд аудит хийж гүйцэтгэхээр тусгасан бөгөөд аудитын сэдэвт он дамжин гүйцэтгэх 3 аудит, хуулийн дагуу гүйцэтгэх 23 аудит, төрийн аудитын байгууллагын бодлогоор гүйцэтгэх 8 аудит байна.

2021 онд хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн 34 аудитаас 21 аудит нь Улсын Их Хурлын Байнгын хороодод, 13 аудит нь холбогдох бусад байгууллагуудад хүргэгдэхээр төлөвлөгдсөн байна. Холбогдох бусад байгууллагуудад хүргүүлэх 13 аудит 2021 онд төлөвлөгөөний дагуу хийгдэж дууссан бөгөөд 2021 онд Байнгын хороодод хүргүүлэх 21 аудитаас 15 аудит бүрэн хийгдсэн, 1 аудит 2022 оны 02 дугаар сарын 10-нд хийгдэж дууссан, үлдсэн 5 аудитын хувьд биелэлтийг нь хангах үйл ажиллагаа үргэлжлэн явагдаж байна. Үүнд:

- “Оюутолгой төсөлд оруулсан хөрөнгө оруулалт, санхүүжилтийн зарцуулалт, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудит нь 2021 онд Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас шалтгаалан биет шалгалт хийх, баримт материалыг татан үзэх боломжгүй байснаас хугацаа хойшилсон байна. 2022 онд аудитын үе шатны ажлууд явагдаж байна.
- Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос өгсөн чиглэлийн дагуу ““Эрдэнэст-Тавантолгой” ХК-ийн 2018-2019 оны үйл ажиллагаа болон Тавантолгойн орд ашиглалтад төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Ашигт малтмалын тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлт” сэдэвт гүйцэтгэлийн аудитын хамрах хүрээг өргөжүүлэн, нэмэлт горим, сорилыг

хэрэгжүүлж байна. 2022 онд аудитын үе шатны ажлууд хэвийн үргэлжилж байна.

- Газрын тостой холбоотой 3 аудитын сэдвийн биелэлт Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахалтай холбоотойгоор 2020 он, 2021 оны эхний хагас жилд хийгдээгүй бөгөөд 2021 оны сүүлийн хагас жилд аудитын үйл ажиллагааг эхлүүлж, одоогоор аудитын ажил хэвийн явагдаж байна.

Хүснэгт 1. Хуулийн дагуу болон Төрийн аудитын байгууллагын бодлогоор гүйцэтгэх аудит

№	Аудитын сэдэв	Хэлэлцүүлэх Байнгын хорооны нэр	Хийгдсэн /+/-
ХУУЛИЙН ДАГУУ ГҮЙЦЭТГЭХ АУДИТ			
1	Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайланд аудит хийх	-	+
2	Төсөл, хөтөлбөрүүдийн санхүүгийн тайланд аудит хийх	-	+
3	Засгийн газрын тусгай сангийн санхүүгийн тайланд аудит хийх	-	+
4	Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн тайланд аудит хийх	-	+
5	Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд аудит хийх	-	+
6	Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайланд аудит хийх	-	+
7	Сангийн яамны 2020 оны санхүүгийн тайланд аудит хийх	-	+
8	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан	Байнгын хороод	+
9	Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл	Байнгын хороод	+
10	Төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, төсөл, хөтөлбөр, сангийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийх	-	+
11	Гүйцэтгэх ажиллагаанд зориулсан хөрөнгийн зарцуулалт	Тусгай хяналтын дэд хороо	+
12	Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх	Төсвийн байнгын хороо	+
13	Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг	Төсвийн байнгын хороо	+
14	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт	Эдийн засгийн байнгын хороо	+
15	Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилт	Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороо	+
16	Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дээд хэмжээ тогтоох	Сонгуулийн ерөнхий хороо	+
17	Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт дэвшүүлсэн зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэхэд болон сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрт дүгнэлт гаргах	Сонгуулийн ерөнхий хороо	+
18	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж, дүнг нийтэд мэдээлэх	Сонгуулийн ерөнхий хороо	+
19	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулах зардлын гүйцэтгэлд аудит хийх	Сонгуулийн ерөнхий хороо	+
20	Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2019-2020 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжүүдийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудит	Эдийн засгийн байнгын хороо	Хийгдэж байгаа.

21	Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2019-2020 онд олборлолтын үйл ажиллагаа явуулсан “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитад	Эдийн засгийн байнгын хороо	Хийгдэж байгаа.
22	Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2014-2020 онд олборлолтын үйл ажиллагаа явуулсан “Петрочайна дачин тамсаг Монгол” ХХК-ийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудит	Эдийн засгийн байнгын хороо	Хийгдэж байгаа.
23	Дархан-Сэлэнгийн бүсэд Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх Концессын гэрээний хэрэгжилт /шинэчлэн сайжруулах-барихашиглах-шилжүүлэх, барих-шилжүүлэх”	Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо, Төсвийн байнгын хороо	+
ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН БОДЛОГООР ГҮЙЦЭТГЭХ АУДИТ			
24	Засгийн газрын шугамаар хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан зээл, тусламжийн ашиглалт, үр дүн	Эдийн засгийн байнгын хороо	+
25	Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилт	Эдийн засгийн байнгын хороо	+
26	Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт	Төсвийн байнгын хороо	+
27	Эрчим хүчний дамжуулалт, түгээлт, үнэ тарифын зохицуулалт, үр нөлөө	Эдийн засгийн байнгын хороо	+
28	Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо	+
29	Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө	Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо	+
30	Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн 2017-2020 оны улсын төсвийн санхүүжилтийн хэрэгжилт, үр нөлөө”	Төсвийн байнгын хороо	+
31	Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн	Боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо, Төсвийн байнгын хороо	+
ОН ДАМЖИЖ ГҮЙЦЭТГЭХ АУДИТ			
32	Оюутолгой төсөлд оруулсан хөрөнгө оруулалт, санхүүжилтийн зарцуулалт, үр нөлөө	Эдийн засгийн байнгын хороо	Хийгдэж байгаа.
33	Засгийн газраас агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр 2017-2020 онд зарцуулсан хөрөнгийн ашиглалт, үр нөлөө	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо	+
34	“Эрдэнэст-Тавантолгой” ХК-ийн 2018-2019 оны үйл ажиллагаа болон Тавантолгойн орд ашиглалтад төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Ашигт малтмалын тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлт”	Эдийн засгийн байнгын хороо	Хийгдэж байгаа.

Эх сурвалж: ТАБ-ын 2021 оны үйл ажиллагааны тайлан

1.2. Төрийн аудитын байгууллагаас 2021 онд хийгдсэн аудитын ажлын хүрээнд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант онд Төрийн аудитын байгууллагаас 10009 зөвлөмж өгсөн бөгөөд үүний 84.5 хувь нь хэрэгжсэн байна. Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд өгсөн зөвлөмжийн 93.6 хувь нь хэрэгжсэн бол гүйцэтгэл, нийцлийн аудитын 38.5 хувь нь хэрэгжжээ. Гүйцэтгэл, нийцлийн аудитын хүрээнд өгсөн зөвлөмжийн 58.1 хувийнх нь хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна.

Аудитаар өгсөн нийт зөвлөмжийн 81.6 хувийг дотоод хяналт, хариуцлагатай холбоотой, 5.4 хувийг хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой, үлдсэн 13.0 хувийг бусад үйл ажиллагаатай холбоотой зөрчлүүдэд өгсөн зөвлөмж эзэлж байна.

Хүснэгт 2. Өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Шийдвэр	Илрүүлэлт		Хэрэгжсэн	Дараа онд шилжих үлдэгдэл
	Эхний үлдэгдэл	Тайлант хугацаанд		
2020 он				
Төлбөрийн акт /тэрбум төгрөг/	14.1	43.1	21.5	34.1
Албан шаардлага /тэрбум төгрөг/	1,876.6	2,297.6	1,185.9	2,987.0
Зөвлөмж /тоо/	1711	9890	10159	1434
2021 он				
Төлбөрийн акт /тэрбум төгрөг/	28.9	59.7	59.2	28.2
Албан шаардлага /тэрбум төгрөг/	2,963.2	2,211.0	3,304.6	1,869.3
Зөвлөмж /тоо/	1367	10009	9626	1750

Эх сурвалж: ТАБ-ын 2021 оны үйл ажиллагааны тайлан

Төрийн аудитын байгууллага 2021 онд нийт 4134 аудитыг гүйцэтгэн 10,091.1 тэрбум төгрөгийн алдаа зөрчлийг илрүүлсэн байна.

Хүснэгт 3. Аудитын илрүүлэлт, хүргүүлсэн зөвлөмж

Аудитын төрөл	Тоо	Аудитын илрүүлэлт /тэрбум төгрөг/	Хүргүүлсэн зөвлөмж
Санхүүгийн тайлангийн аудит	3906	9,489.1	8358
Гүйцэтгэл, нийцлийн аудит	228	602.0	1651

Эх сурвалж: ТАБ-ын 2021 оны үйл ажиллагааны тайлан

Түүнчлэн Төрийн аудитын байгууллага 2021 онд бүх шатны төсвийн захирагчдын төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн тайланд аудит хийж бие даасан 3906 дүгнэлт гаргасны зэрэгцээ гүйцэтгэл, нийцлийн 228 аудитыг 7174 байгууллага, хуулийн этгээдийг хамруулан хийж гүйцэтгэсэн байна.

Тайлант хугацаанд Төрийн аудитын байгууллага батлагдсан сэдвийн дагуу нэгдсэн удирдамжаар 122, өөрсдийн санаачилгаар 75, УИХ, аймаг, нийслэлийн ИТХ-ын хүслээр 29, өргөдөл, гомдлын дагуу 2 аудитыг гүйцэтгэн УИХ-ын Төсвийн байнгын хороо болон аймаг, нийслэлийн ИТХ-д танилцуулсан байна.

2021 онд гүйцэтгэсэн аудитын илрүүлэлтийн 47.7 хувь нь нягтлан бодох бүртгэлийн тайлагналтай, 37.2 хувь нь дотоод хяналт, хариуцлагатай, 9.7 хувь нь хууль, тогтоомжийн хэрэгжилттэй, 1.5 хувь нь үр нөлөө, арвилан хэмнэлт, үр

ашигтай, 1.4 хувь нь худалдан авалттай, 2.5 хувь нь бусад үйл ажиллагаатай тус тус холбоотой байна.

Аудитын гүйцэтгэлээр илрүүлсэн алдаа, зөрчлийн 5,911.2 тэрбум төгрөг буюу 58.6 хувийг аудитын явцад залруулаагүй, 4,179.9 тэрбум төгрөг буюу 41.4 хувийг аудитын явцад залруулсан байна.

Нийт залруулсан алдааны 99.3 хувь нь нягтлан бодох бүртгэл, тайлагналтай, 0.1 хувь нь төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй, 0.1 хувь нь бусад үйл ажиллагаатай, 0.5 хувь нь хууль тогтоомжийн хэрэгжилттэй тус тус холбоотой байгааг тайланд тусгажээ.

Нийгмийн шаардлага, өнөөгийн нөхцөл байдалтай холбогдуулан Төрийн аудитын байгууллагын бодлогоор гүйцэтгэсэн “Хүнсний аюулгүй байдлыг хянах, өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн”-д аудит хийсэн нь онцлон дурдууштай байна. Монгол Улсын хэмжээнд мөрдөгдөж байгаа хүнсний холбогдолтой үндэсний 693 стандартын 39.2 хувь нь гадаад орны дэвшилтэт стандартын түвшинд хүрсэн, 60.8 хувь нь стандарттай уялдуулан боловсруулсан байгааг аудитын тайланд дүгнэсэн байна. Хийсэн аудитын үр дүнд улс, орон нутгийн лабораторийн тоног төхөөрөмжийн шинэчлэл, урсгал болон их засвар хийдэггүй, эм урвалжийн төсөв хангалтгүй, хүнсний шим тэжээл, чанар, аюулгүй байдалд хийж буй шинжилгээ чанаргүй, өндөр хүчин чадалтай лабораторийг ашиглахгүй байгаа зэрэг нөхцөл байдлыг илрүүлэн холбогдох байгууллагуудад 23 зөвлөмжийг хүргүүлж ажиллажээ.

ХОЁР. ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Төрийн аудитын байгууллагын 2020 оны үйл ажиллагааны тайланг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцээд үйл ажиллагааны тайлантай холбогдуулан үүрэг, чиглэл өгсөн тогтоол гаргаагүй болно.

Харин Байнгын хорооны гишүүдээс (1) төрийн хяналтыг хэрэгжүүлдэг аудиторуд өргөн цар хүрээний мэдлэгтэй, үнэн зөв дүгнэлт өгөх чадвартай байхын тулд мэдлэг боловсролоо байнга дээшлүүлэх, (2) нийцлийн болон гүйцэтгэлийн аудит хийх явцдаа санхүү, төсвийн эрх зүйн зохицуулалтуудын хоорондын уялдааг хангах, төсвийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр аудитын байгууллага санал, дүгнэлтээ оруулж ирдэг байх зэрэгт анхаарч ажиллах талаар зөвлөсөн байна. Өгсөн зөвлөмжүүдийн хэрэгжилтийг дурдвал дараах байдалтай байна.

2.2. Мэдлэг боловсролоо байнга дээшлүүлж байх хүрээнд:

Төрийн аудитын байгууллага аудиторудын мэдлэг, чадварыг байнга дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд 2021 онд сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу нийт 53 төрлийн гадаад болон дотоод сургалтыг давхардсан тоогоор 5455 албан хаагчдыг хамруулан танхим, цахим, онлайн хэлбэрүүдээр зохион байгуулж ажилласан байна.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үеийн нөхцөл байдлыг тооцон нийт сургалтын 91 хувийг цахимаар, 9 хувийг танхимаар тус тус зохион байгуулжээ. Түүнчлэн Төрийн аудитын байгууллагын аудиторуд болон санхүүгийн тайлангийн аудитыг гэрээгээр гүйцэтгэж буй аудитын үйл ажиллагаа явуулдаг 60

хуулийн этгээдийн 337 аудиторыг цахим сургалтын системээр 3 багц, 36 сэдэв бүхий, нийт 144 цагийн сургалтад хамруулж мэдлэг, чадварыг нь дээшлүүлэхэд анхаарч ажилласан байна.

Цахим сургалтын системийг ашиглан аудиторуудад мэдлэг, чадвараа тасралтгүй дээшлүүлэх боломжийг олгох үүднээс 76 сэдвээр мэргэжлийн сургалтын багц, 31 сэдвээр хөгжлийн сургалтын багц, “MOOC” /Mongolian open online course/ сургалтын 26 багцыг бэлтгэн дотоод сүлжээндээ байршуулсан байна.

2.2. Нийцлийн болон гүйцэтгэлийн аудит хийж байх явцад санхүү, төсвийн эрх зүйн зохицуулалт хоорондын уялдааг хангадаг байх, төсвийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр аудитын байгууллага санал, дүгнэлтээ оруулж ирүүлдэг байх хүрээнд:

Аудитын явцад илрүүлсэн зөрчлүүдийг арилгах, таслан зогсоох, санхүү, төсвийн эрх зүйн зохицуулалт хоорондын уялдааг хангаж ажиллах чиглэлээр 7.0 тэрбум төгрөгийн акт тогтоож, 740 зөрчилд албан шаардлага, 1651 зөвлөмж өгч, 25 албан тушаалтанд хариуцлага тооцуулж, 42 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж бүрэн шийдвэрлүүлсэн байна. Төрийн аудитын байгууллага 2021 онд гүйцэтгэсэн аудитын дүгнэлтдээ үндэслэн төсвийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр 176 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн байна. 2020, 2021 онд нийт 226 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлагыг хүргүүлсэн бөгөөд албан шаардлагын 89.4 хувь нь шийдвэрлэгдсэн байна.

ГУРАВ. ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ЭСЭХ ТАЛААР

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны “Системчилсэн үнэлгээ хийх тухай” 05 дугаар тогтоолоор Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагуудад үйл ажиллагааны тайлангаа Улсын Их Хуралд ирүүлэхдээ “Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийж ирүүлэх үүрэг өгөгдсөн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 113.1 дэх хэсэгт заасны дагуу Төрийн аудитын байгууллага нь 2021 оны үйл ажиллагааны тайлан болон системчилсэн үнэлгээ хийсэн тайлангаа Төсвийн байнгын хороонд 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 740 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Төрийн аудитын байгууллага нь 2021 оны үйл ажиллагааны тайландаа системчилсэн үнэлгээ хийхдээ үйл ажиллагааны тайлан, байгууллагын бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн судалгаа, харилцагч талуудын оролцоо, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай ажилласан талаарх судалгаа, мэдээллийн технологи өгөгдлийн сан, мэдээллийн аюулгүй байдал, сургалт хөгжил, үндсэн үйл ажиллагаа, 2021 онд төлөвлөсөн аудит гүйцэтгэлийн талаарх судалгаа, 2021 оны санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад холбогдох баримт материалд тулгуурлан тулгарч буй бэрхшээл болон цаашид шийдвэрлэх асуудлын талаар санал, дүгнэлт гаргасан байна.

3.1. Байгууллагын чиг үүрэг, 2021 оны гүйцэтгэлийн тайланд хийсэн үнэлгээний талаар:

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд “Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно” гэж хуульчилсны дагуу Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2020 оны 05 дугаар сарын 01-ний өдөр батлагдаж, 2020 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн.

Тус байгууллага нь 2021 онд “Аудитыг цахимжуулж нэгтгэн удирдах тогтолцоог бүрдүүлэн төлөвшүүлэх” зорилтын хүрээнд мэдээллийн системийг хөгжүүлэх стратегийн бодлогын хэрэгжилтийн явцыг хурдасгах, мэдээллийн технологид нийцүүлэн аудитыг дэмжих, их өгөгдөлд суурилсан аудитын мэдээлэлд дүн шинжилгээ хийх, тайлагналын тогтолцоог цахим хэлбэрт шилжүүлэх, зохион байгуулалтын бүтцийн нэгж бүрийг технологийн дэвшилтэт шийдэлтэй уялдуулан систем, программ хангамжийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлэх бодлогыг баримтлан ажиллажээ.

Төрийн аудитын байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 бүлэг, 18 зорилтын хүрээнд 133 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж үр дүн 88.5 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Тус байгууллага нь тайлант хугацаанд 7174 байгууллага, хуулийн этгээд, тэдгээртэй холбогдох талуудын үйл ажиллагааг хамруулсан санхүүгийн тайлангийн 3906, гүйцэтгэл, нийцлийн 228 нийт 4134 аудитыг хийж гүйцэтгэн 10.0 их наяд төгрөгийн алдаа зөрчлийг илрүүлэн, шалгуулагч этгээдэд 59.7 тэрбум төгрөгийн төлбөрийн акт, 2.2 их наяд төгрөгийн албан шаардлага, 10 мянган зөвлөмж хүргүүлж, 49 асуудлыг хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлж, 202 албан тушаалтанд хариуцлага тооцуулж, улс, орон нутгийн төсөвт 53.1 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Түүнчлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын 123 тушаал гарсны 113 нь буюу 91.9 хувь нь бүрэн хэрэгжсэн байна. Харин 8 нь буюу 6.5 хувь нь хэрэгжих шатанд, үлдсэн 2 нь хэрэгжих хугацаа болоогүй гэсэн гүйцэтгэлийн ангилалд тус тус байна. Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаалаар 2021 онд нийт 17 дүрэм, журам, заавар, аргачлалыг шинэчлэн боловсруулж, үйл ажиллагаандаа мөрдөн ажилласан байна.

3.2. Хүний нөөцийн хэрэгцээнд хийсэн үнэлгээний талаар:

Төрийн аудитын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3, 29 дүгээр зүйлийн 29.1.10, 29.3 болон Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 06 дугаар тогтоолыг үндэслэн Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын бүтэц, бүтцийн нэгжүүдийн үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэл, орон тоо, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/02 дугаар тушаал гарснаар Үндэсний аудитын газрыг 10 газар, 4 хэлтэс 168 албан хаагчтай, нийслэл дэх Төрийн аудитын газрыг 4 хэлтэс 55 албан хаагчтай, 21 аймаг дахь Төрийн аудитын газрыг 247 албан хаагчтай ажиллуулахаар шинэчлэн зохион байгуулжээ.

Тайлант онд Төрийн аудитын байгууллагын шинэчлэн баталсан бүтэц зохион байгуулалт, орон тоо, чиг үүргийн өөрчлөлтийн дагуу Аудитын нэгдүгээр газар, Мэдээллийн технологийн төв, Харилцаа хамтын ажиллагааны газар гэсэн шинэ бүтцийн нэгжүүдийг байгуулж Үндэсний аудитын газарт 168, нийслэл дэх Төрийн

аудитын газарт 55, орон нутаг дахь Төрийн аудитын газарт 247 нийт 470 албан хаагч ажилласан байна.

Төрийн аудитын байгууллагад мэргэжил, ур чадвар, ажлын туршлагатай хүний нөөц бүрдүүлэн ажиллуулах бодлогын хүрээнд тусгай “Комисс” томилон 3 хэсгээс бүрдсэн шалгалтыг 5 удаа зохион байгуулж тэнцсэн албан хаагчдыг албан тушаалд нэр дэвшүүлэн томилж, удирдах болон гүйцэтгэх түвшний сул орон тоог нөхөж ажилласан тухай тайланд дурдсан байна.

3.3. Олон нийтийн харилцаа, хамтын ажиллагааны үнэлгээний талаар:

Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчилж, мэдээллийн урсгалыг сайжруулах зорилгоор олон нийттэй харилцах хамтын ажиллагааг чухалчлан Үндэсний аудитын газрын үйл ажиллагаа, бодлого шийдвэртэй холбоотой цаг үеийн болон аудитын талаарх нийт 121 удаагийн мэдээллийг www.audit.mn сайтад байршуулж ажилласан байна. Түүнээс гадна аудитын байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд хүргэх, аудитын дүн, дүгнэлтийг таниулах зорилгоор 8 видео контент, 12 подкастыг бэлтгэн олон нийтийн мэдээлэл, сурталчилгааны сувгаар түгээсэн байна.

3.4. Мэдээллийн технологи, цахим үйл ажиллагааны үнэлгээний талаар:

Төрийн аудитын байгууллагын албан хаагчид болон аудитын хуулийн этгээдүүдийн ашиглах шалгагдагч этгээдийн бүртгэл, хүний нөөцийн бүртгэл, шилэн дансны мэдээний нэгтгэл, статистикийн мэдээний нэгтгэл, сонгуулийн хандивын зардалд хяналт тавих систем, “нээлттэй аудит” портал сайт, санхүүгийн тайлангийн аудитын систем, хяналт-шинжилгээ, үнэлгээний программ, нэвтрэлтийн нэгдсэн системүүдийн хөгжүүлэлтийг хийж мэдээллийн сан үүсгэснээс гадна www.audit.mn, open.audit.mn, able.audit.mn, dev.audit.mn дэд домайн системүүдийг албан ёсны SSL сертификаттай болгосон байна. Түүнчлэн мэдээллийн технологийн найдвартай ажиллагааг хангахын тулд Төрийн аудитын байгууллагын хэмжээнд ашиглаж буй компьютер системүүдийг антивирусын болон оффис 365 албан ёсны лицензтэй болгох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийж гүйцэтгэсэн талаар тайланд тусгасан байна.

3.5. Санхүү буюу захиргааны зардлын үнэлгээний талаар:

Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүгийн тайлагнал, шилэн данс, худалдан авах ажиллагаа гэсэн 5 асуудлын хүрээнд үнэлгээг хийсэн бөгөөд Төрийн аудитын байгууллагын 2021 оны төсвийн төсөлд 28.9 тэрбум төгрөгийг төлөвлөж Сангийн яаманд хүргүүлсэн боловч 2021 оны Төсвийн тухай хуулиар урсгал санхүүжилтэд 25.4 тэрбум, хөрөнгийн зардалд 1.5 тэрбум, нийт 26.7 тэрбум төгрөг батлагдаж, төсвийн урьдчилсан гүйцэтгэлээр 24.2 тэрбум төгрөг буюу батлагдсан төсвийн 90.0 хувийг зарцуулж 2.7 тэрбум төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

- ✓ Шилэн дансанд байршуулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа байршуулсан 139, хугацаа болоогүй 5, хугацаа хоцроосон 2 мэдээлэл байгааг үнэлгээгээр илрүүлсэн байна.
- ✓ Тайлант хугацаанд 1,723.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 19 төсөл, арга хэмжээний худалдан авалтыг хийх төлөвлөгөөг батлан 907.3 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээг худалдан авах ажлыг зохион байгуулж, 841.5 сая төгрөгийн гэрээ байгуулсан бол 816.6 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээг худалдан авах ажил цуцлагдсан байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.3 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газраас Төрийн аудитын тухай хууль тогтоомжийн биелэлтийн талаарх Үндэсний аудитын газрын 2021 оны тайланд шинжилгээ хийлээ.

Тамгын газраас шинжилгээг гүйцэтгэхдээ Үндэсний аудитын газраас Төрийн аудитын тухай хуульд заасан чиг үүргээ 2021 онд хэрхэн хэрэгжүүлэн ажилласан талаар болон “байгууллагын чиг үүргийн хэрэгжилт”, “хүний нөөц”, “олон нийт, хамтын ажиллагаа”, “мэдээллийн технологи, цахим үйлчилгээ”, “байгууллагын төсөв, санхүүгийн үйл ажиллагаа”-нд хийсэн системчилсэн үнэлгээ хийсэн эсэхийг харгалзсан болно.

Төрийн аудитын байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 бүлэг, 18 зорилтын хүрээнд 133 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж үр дүн 88.5 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Төрийн аудитын байгууллага нь үйл ажиллагааны тайландаа системчилсэн үнэлгээ хийж гүйцэтгэхдээ “Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлал”-ыг мөрдлөг болгожээ.

Тус байгууллага нь мэдээллийн урсгал, цахим технологийн ашиглалтыг сайжруулах, ажилтнуудыг сургах, мэргэшүүлэх, зохион байгуулалтын шинэ бүтэц, орон тоогоор ажиллуулах, бүтээмжийг нь дээшлүүлэх, гэрээт ажилтны тоог цөөлөх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлөөр хангахад чиглэгдсэн тодорхой ажлуудыг хэрэгжүүлж ажилласан байна.

Үйл ажиллагааны тайлангаас харахад хэрэгжилт хангалттай буюу бүрэн хэрэгжсэн, үр дүнтэй арга хэмжээнүүдийг голчлон тайлагнасан бөгөөд тайлант онд хэрэгжээгүй болон хэрэгжилт хангалтгүй үлдсэн хэдэн арга хэмжээ байгаа, тэдгээрийн шалтгааны талаар тайлагнаж ирүүлээгүй байна.

Гүйцэтгэхээр төлөвлөсөн боловч хэрэгжээгүй ажлын шалтгаан нөхцөлийг тодруулан тайлагнаж ирүүлэх, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд тулгарч байгаа хүндрэлтэй асуудлуудын талаар тайлагнах нь дараа оны үйл ажиллагааг оновчтой төлөвлөх, улмаар шийдвэрлэх гарцыг тодорхойлоход ач холбогдолтой юм.

Цаашид Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1-т заасны дагуу Үндэсний аудитын газар нь тухай жилийн үйл ажиллагааны тайлангаа Улсын Их Хуралд ирүүлэхдээ Төрийн аудитын тухай хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлэн ажилласан талаар тайлагнах шаардлагатай байна.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗАР